| 3.2.3 | Арга хэмжээ-5.5 Соёл, урлагийн байгууллага, концертын танхим, караоке, бар, ресторанд оюуны өмч, зохиогчийн эрхийн талаарх тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж шаардлагатай арга хэмжээг авч ажиллах. | Орон нутгийн төсөв | Арга хэмжээ зохион байгуулсан байх. | - | Дүгнэлтийг Соёлын яаманд ирүүлсэн байх. | Соёлын Сайдын 2023 оны А/109 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэг тус аймагт ажиллаж, Залуучууд театр, Музей, Төв номын сан, Хүүхдийн номын ордон, Хонгор сумын Соёлын төв, Өргөө кинотеатр, 2 караоке, Гранд як ХХК-ийн эвент танхимын үйл ажиллагааг эрсдэлийн шалгуур үзүүлэлт, хяналтын хуудсаар үнэлж, оюуны өмч, зохиогчийн эрхийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч зөвлөн тусалсан.<br>Удирдамжийн дагуу хийгдсэн тандалт судалгааны дүнг илтгэх хуудсаар танилцуулгын хамт Соёлын яаманд хүргүүлсэн. | 100 % |
| **Зорилт-3.3. Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, үндэсний соёлын дархлааг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 3.3.1 | Арга хэмжээ-1.4 Соёлын үнэт зүйлсийг судлан соёлын орчин, орон зай, брэндийг | Улсын болон орон | Соёлын орон зай, бүтээгдэхүүн үйлчилгээг | - | Соёлын нөөц, орон зайд тулгуурласан соёлын аялал | Дархан-Уул аймаг олон улсын кино уран бүтээлчдийн анхаарлыг татах онцгой бүс болон соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх бүрэн боломжтой учир “Нээлттэй Дархан” хөтөлбөрийг | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бий болгох чиглэлээр дэмжлэг үзүүлэх. | нутгийн төсөв | эдийн засгийн эргэлтэд оруулсан эсэх | | жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авсан байна. | хэрэгжүүлэх арга хэмжээний 5.3.3-т “Нээлттэй хот” уриалга дэвшүүлж орон нутагт кино үйлдвэрлэлийн чиглэлээр олон талт үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал: “Vivant” ОАУСК-ны хэсэгчилсэн зураг авалтыг хоёр сарын хугацаанд Дархан хотноо хийсэн. Энэхүү кино нь Монгол Улсын нутаг дэвсгэрт богино хугацааны зураг авалт хийхдээ нийт 6 тэрбум гаруй төгрөгийн эдийн засгийн эргэлтийг улсын хэмжээнд бий болгосон бол үүний 2.2 тэрбум төгрөгийг Дархан-Уул аймагт зарцуулсан нь мэдлэгт суурилсан бүтээлч үйлдвэрлэлийн эдийн засаг хөгжих нөөц бололцоог харуулж байгаа юм.<br><br>:**Хүрсэн түвшин**<br>Соёлын нөөц, орон зайд тулгуурласан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр Кинонд ээлтэй хот болох зорилт дэвшүүлэн тодорхой үр дүнд хүрсэн. Соёлын сэргэлт-2023” аяны “ хүрээнд Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнд Кино орон зай кино гудамж” соёлын орон зайн “ .төслийн нээлтийг хийсэн“Кинонд ээлтэй хот” болж соёлын орон зайг бий болгосноорсоёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх таатай боломж .бүрдэх юм | |
| 3.3.2 | Арга хэмжээ-1.7 Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх соёлын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | Орон нутгийн төсөв | Дэмжлэг үзүүлэн зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 6-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | 1. Залуучууд театр нийтдээ 11 арга хэмжээг 31 удаа зохион байгуулж 2126 хүнийг хамруулсан.<br>.2Музей тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан 7 удаагийн арга хэмжээг зохион байгуулж 350 гаруй хүүхэд, ахмад настныг хамруулсан. Мөн гэр оронгүй зорилтод бүлгийн иргэдийг соёлын боловсролын хөтөлбөрт хамруулсан.<br>.3Хүүхдийн номын ордон 14 ахмад настанд, 35 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд, тусгаарлах байрны 12 уншигчдад үнэ төлбөргүй карт нээж, зөөврийн номын сангаар 6 удаа 150 боть ном, 5 уншигчдад гэрээр 11 удаа 19 боть ном хүргэж үйлчилсэн. | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | .4Төв номын сан зорилтот бүлгийн 500 иргэдэд 750 боть номоор үйлчилж, үнэ төлбөргүй 290 карт нээлээ.<br>5.Шарын гол сумын Соёлын төв 5 арга хэмжээг зохион байгуулж, 48 тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд соёл, урлагийн үйлчилгээний хүртээмжийг хүргэсэн.<br>.5Дарханы Зураач урчуудын эвлэл 1 арга хэмжээг зохион байгуулж 12 хүүхдийг хамруулсан.<br>.6Тэгш хүртээмжтэй нийгмийг цогцлоох, Монгол үндэстний ижилсэл ба ялгарлыг дэлхийд таниулах зорилгоор "Трио" уран сайхны киноны нээлтийг Дархан хотноо хамтран зохион байгуулсан. Нээлтийн орлогыг Даунтай хүүхдийн эцэг эхийн холбоонд хандивласан.<br>.7"Зүрхэнд гэрэлтэх од" МУСК-ны нээлтэд даунтай болон хөгжлийн бэрхшээлтэй 30 хүүхдийг урилгаар оролцуулсан.<br>**:Хүрсэн түвшин**Тусгай хэрэгцээт болон зорилтот бүлгийн иргэдэд зориулж нийт7 арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсэн. Энэхүү арга хэмжээнүүдэд 3079 хүнийг хамрагджээ. | |
| 3.3.3 | Арга хэмжээ-2.8 Хүчирхийллийг илэрхийлж, сурталчилсан агуулга бүхий соёл, урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлэх. | Орон нутгийн төсөв | Хуулийн хэрэгжилт хангагдаж, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн эсэх | СӨБ-ын хүүхдэд зориулсан зохиол бүтээлийн цахим сан байгуулж, үг хэллэгийн бүртгэл гарсан. | Судалгаа-1, санал зөвлөмж-1 | 1. Хүчирхийллийг илэрхийлж, сурталчилсан агуулга бүхий соёл, урлагийн арга хэмжээ, аливаа уран бүтээл, утга зохиолыг нийтэд түгээхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр соёлын байгууллагуудад албан бичгээр чиглэл хүргүүлж ажилласан.<br>2. Соёлын 7 байгууллага соёлын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, хүний эрх, гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр туурвиж буй соёлын хөтөлбөрүүдийг сайжруулах зорилгоор 7 судалгааг авч нийт 2302 хүн хамруулж үйл ажиллагаандаа ашигласан байна.<br>3. ГХУСАЗЗөвлөлийн санаачилгаар хүчирхийллийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, мэдлэг олгох зорилгоор бүтээсэн | 90%<br><br>100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Нарны сүүдэр” МУСК-г оюуны өмчийн эрхийн зөвшөөрөлтэйгөөр сумдын Соёлын төвүүдэд гаргасан. Энэ үеэр сумдын Цагдаагийн тасагтай хамтран “Ээжтэйгээ болзоо” арга хэмжээг зохион байгуулж 65 гэр бүлд зөвлөмж өгч, хүүхэд, эцэг эхчүүдийг судалгаанд хамруулсан.<br>4. “Хөшиг нээгдэх бүрт-хүргэх нэг үг” аяны хүрээнд соёлын 7 байгууллага нийт 18 нөлөөллийн ажил хийж 278ш хүчирхийллийн эсрэг материал хэвлэн тарааж, цахим орчинд 6 зурагт хуудас бэлтгэн байршуулж зөвлөмж хүргэж ажиллалаа. | |
| 3.3.4 | Арга хэмжээ-3.5 Үндэсний баяр наадмын соёл, урлагийн арга хэмжээг нэгдсэн өнгө төрх, агуулгад нийцүүлэн зохион байгуулах. | Орон нутгийн төсвөөс сая 60.6 | Нэгдсэн өнгө төрхтэй зохион байгуулагдсан эсэх | - | Улсын хэмжээнд нэгдсэн өнгө төрх, агуулгад нийцүүлэн зохион байгуулсан байна. | -Ардын хувьсгалын 102 жил, Дархан хот байгуулагдсаны 62 жилийн ой, аймгийн баяр наадам, нээлт, хаалтын ёслолын үйл ажиллагаар “ЭВ МӨНХИЙН ТУСГААР МОНГОЛ” нэрийн дор зохион байгууллаа. Наадмын нээлт, бусад урлаг соёлын үйл ажиллагаанд Залуучууд театрын болон чөлөөт уран бүтээлчид, бүжгийн дугуйлангийн авьяаслаг хүүхэд багачууд, төрийн байгууллагын нийт 500 гаруй хүн оролцсон.<br>-“ХӨХ ТЭНГЭРИЙН ОРОН” хүндэтгэлийн тоглолтыг Залуучууд театрт 2 удаа тоглож, 1182 иргэнд толилуулсан. Энэ жилийн хүндэтгэлийн тоглолтод Залуучууд театрын 60 уран бүтээлч оролцсон.<br>-Аймгийн Музейгээс Дарханы хөгжил дэвшлийг харуулсан 50 орчим гэрэл зургаар “ДАРХАНЫ ХӨГЖИЛ-ГЭРЭЛ ЗУРАГТ” үзэсгэлэнг эрхлэн гаргалаа.<br>- Дэлхийн өнцөг булан бүрт байгаа хүн бүхэн орон зай, цаг хугацааны хязгааргүйгээр хандаж, наадамтай холбоотой цаг үеийн мэдээ мэдээллийг авах зорилготой Үндэсний их баяр наадмын албан ёсны цахим хуудас, олон нийтийн сүлжээ буюу enaadam.mn - Үндэсний их баяр наадам цахим хуудсанд Дархан-Уул | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн баяр наадамтай холбоотой нийт 45 мэдээ мэдээлэл нийтэллээ.<br><br>**Хүрсэн түвшин:** Улсын хэмжээний нэгдсэн өнгө төрх, агуулгад нийцүүлэн үндэсний баяр наадмын үйл ажиллагаар нэгдсэн ажлын хэсэгтэй хамтран зохион байгуулсан. | |
| 3.3.5 | Арга хэмжээ-4.20 Аймгийн музейн шинэ барилгыг ашиглалтад оруулах. | Улс, орон нутгийн төсөв | Боловсруулсан интерьерийн зураг төсөв | Батлагдсан ажлын даалгавар | Музейн барилгыг ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлж, интерьерийн зураг төслийг боловсруулсан байна. | Эдийн засгийн хөгжлийн сайдын 2023 оны багцад тус музейн интерьер, заслын ажилд 200,0 сая төгрөг батлуулж, тус яам "Эрхэс Констракшн" ХХК-тай 2023.07.05-ны өдөр 174,1 сая төгрөгийн гэрээ байгуулан, зураг төсвийг 12 дугаар сард багтаан дуусгах гэрээтэй ажиллаж байна.<br>Тус арга хэмжээг Соёлын яам эрхлэн зохион байгуулж хяналт тавьж байгаа болно. Тус аймгийн Соёл, урлагийн газарт эрх шилжиж ирээгүй.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>Музейн интерьер, заслын ажлыг "Эрхэс Констракшн" ХХК 174,1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна.<br>Тус арга хэмжээнд Соёлын яамнаас хяналт тавьж байна. Орон нутагт эрх шилжиж ирээгүй. Орон нутгаас шалтгаалахгүй. | 70%<br><br>!!!!! |
| 3.3.6 | Арга хэмжээ-5.2 Аймгийн төв, томоохон сум, суурин газрыг соёлын өвөрмөц дахин давтагдашгүй хэв шинжийг агуулсан "Бүтээлч хот" хэлбэрээр хөгжүүлэх бодлогын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах. | Орон нутгийн төсөв | Төлөвлөгөө батлагдсан эсэх | - | Баримт бичгийн хувийг Соёлын яаманд ирүүлсэн байна. | -"Нээлттэй Дархан" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 5.3.3-т "Нээлттэй хот" уриалга дэвшүүлж орон нутагт кино үйлдвэрлэлийн чиглэлээр олон талт үйл ажиллагаар зохион байгуулахаар төлөвлөсөн. :Үүний дагуу оны 2023 -9 дүгээр сарын 23-ны өдөр кино үйлдвэрлэлийг дэмжих, соёлын бүтээлч үйлдвэрлэлээр дамжуулан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр аймгийн Засаг дарга болон МҮКУЗөвлөлийн дарга нар хамтран ажиллах Санамж бичиг байгуулсан.<br>- Киноны орчин бүхий гадаад дотоод жуулчид, аялагчдын сонирхол татахуйц, кино | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлдвэрлэлийг дэмжих бодлогыг илэрхийлсэн соёлын орон зайг бий болгох санаачлагыг эхлүүллээ. Кино орон зайг “Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэнд буюу “Гарын таван хуруу” киноны зураг авалт хийж байсан газарт байгуулахаар тогтож тохижилтын эскиз төсөлтэй Соёлын сайд Ч.Номин, Сангийн сайд Б.Жавхлан, аймгийн Засаг дарга Б.Азжаргал нарын холбогдох албаныхан, кино уран бүтээлчид танилцлаа. Тус үйл ажиллагаанд аймгийн Музейгээс Дархан хотод зураг авалт нь хийгдсэн киноны зургуудаас бүрдсэн гэрэл зургийн үзэсгэлэнг дэглэж олон нийтэд толилуулав.<br>**Хүрсэн түвшин:** “Бүтээлч хот” хэлбэрээр хөгжүүлэх бодлогын хүрээнд “Кинонд ээлтэй хот” болох зорилт дэвшүүлсэн. Энэ дагуу аймгийн ИТХ-ын 2023 оны 09 дүгээр тогтоолоор баталсан “**Нээлттэй Дархан” хөтөлбөр**т тус асуудлыг тусгуулсан. Мөн хэрэгжилтийг хангах зорилгоор **Санамж бичиг** боловсруулж талууд гарын үсэг зурсан. | |
| **Гурав. Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлын хүрээнд:** | | | | | | | |
| **Зорилго-4.2. Хүний нөөц, сургалт, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.** | | | | | | | |
| 4.2.1 | Арга хэмжээ-1.1 Соёл, урлагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох. | Улсын болон орон нутгийн төсөв | Соёл, урлагийн байгууллагад менежментийн шинэчлэл хийгдснээр | МУЗГ-ын 2021 оны 377 дугаар тогтоол | Соёл, урлагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтад менежментийн шинэчлэл хийгдсэн байна. | 1. Тус газар нь Захиргаа, удирдлагын хэлтэс, Соёл, урлагийн хэлтэс гэсэн 2 нэгжтэйгээр, бүтэц, орон тооны хувьд **11** ажилтан, албан хаагч ажиллахаас онд 2023нийт **9** орон тоотойгоор үйл ажиллагаагаа явууллаа. Төрийн байгууллагын хэвийн үйл ажилагааг хангах хүрээнд 2024 оны төсөвт 1 үйлчлэгчийн орон тоог нэмэгдүүлэх саналыг Соёлын яаманд хүргүүлж, шийдвэрлүүлсэн.<br>2. Тус газрын харьяа соёлын 7 байгууллагын бүтэц, орон тоог баталсан, цалин хөлсийг шинэчлэн тогтоосон шийдвэрт хяналт хийж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч, нарийн бичгийн ажилтан, архивын эрхлэгч зэрэг **17** албан тушаалтнаас тодруулга авч, чиг үүргийн хүрээнд зөвлөгөө өгч ажилласан. Энэ | 70%<br><br><br><br>90% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дагуу аймгийн Засаг даргаас батлах соёлын 4 байгууллага/театр, номын сан, номын ордон, музей/ бүтэц орон тооны саналыг шинэчлэн боловсруулж ирүүлснийг аймгийн ЗДТГ-ын НБХ-т уламжилсан.<br><br>3.Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ, СУГ-ын дарга нарын хамтран баталсан “Зөвлөн туслах ажлын удирдамж”-ийн дагуу ТАЗ-ийн 2019 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын хэрэгжилттэй танилцах, хүний нөөцтэй холбоотой шийдвэр, баримт бичигт үзлэг хийж, цахим системд нэвтрэн хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах чиг үүргийг ДУА дахь ТАЗСЗ-тэй хамтран хэрэгжүүлсэн. Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай, Соёлын тухай хуулиуд болон Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам, Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам, Хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх, хадгалах журам, Албан хэрэг хөтлөлтийн стандартын хэрэгжилтийг бүрэн хангуулах, дотоод хяналтыг сайжруулах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн.<br><br>**:Хүрсэн түвшин**<br>Соёл, урлагийн газрын бүтэц, орон тоог 1-ээр -<br>.нэмэгдүүлэх санал хүргүүлж шийдвэрлүүлсэн<br>Харьяа соёлын 7 байгууллагын бүтэц, орон -<br>тоогбаталсан, цалин хөлсийг шинэчлэн тогтоосон шийдвэрийг хянаж чиг үүргийн хүрээнд зөвлөмж өгсөн. Энэ дагуу аймгийн Засаг даргаас батлах соёлын 4 байгууллага/театр, номын сан, номын ордон, музей/ бүтэц, орон тооны саналыг шинэчлэн боловсруулж ирүүлснийг аймгийн ЗДТГ-ын НБХ-т уламжилсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Сумдын соёлын төвүүдийн үйл ажиллагаанд Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Төсвийн тухай, Соёлын тухай хуулиудын хэрэгжилт дунджаар 82.9%, "Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Соёлын төв, соёлын ордон. Орчин ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага" MNS 6981:2022 стандартын хэрэгжилт 75. хувьтай байсан 2хэрэгжилтийг 90 хувьдхүргэ.лээ | |
| 4.2.2 | Арга хэмжээ-1.2 Аймгийн Соёл, урлагийн газрын бүтцэд соёлын байцаагчийн орон тоог бий болгох, ажиллах нөхцөлөөр хангах. | Улсын болон орон нутгийн төсөв | Улсын байцаагчтай болсон байх. | - | Соёлын улсын байцаагчтай болсон байна. | - Улсын байцаагчтай болох асуудлаар Соёлын яаманд албан бичиг хүргүүлсэн.<br><br>- МУЗГ-ын 2023 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам"-д заасны дагуу тус газрын даргад улсын ахлах байцаагчийн, Захиргаа удирдлагын хэлтсийн даргад улсын байцаагчийн эрх олгуулах хүсэлтийг Соёлын яаманд бичгээр хандаж гаргасан.<br><br>- Улсын байцаагчийн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд "Салбарын хяналт шалгалтын 2023 оны төлөвлөгөө"-нд тусгагдсан дараах ажлуудыг хийж гүйцэтгэн тайланг Соёлын яаманд хүргүүлсэн. Үүнд:<br>- Соёлын салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах **4** шалгуур үзүүлэлт, **8** хяналтын хуудсаар **90** объектод эрсдэлийн үнэлгээ хийж, шилэн хяналтын цахим системд мэдээллийг оруулсан. Үүнээс **6** нь бага, **46** нь дунд, **38** нь их эрсдэлтэй үнэлэгдсэн.<br>- "Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын 2022 оны тооллогын мөрөөр урьдчилан сэргийлэх шалгалт хийх тухай" хяналт шалгалтын удирдамжийн дагуу төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх шалгалтыг тус газрын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн хийж гүйцэтгэсэн. | 50%<br><br>90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүрсэн түвшин:<br>- Улсын байцаагчтай болох асуудлаар Соёлын яаманд 2 удаагийн албан бичиг хүргүүлсэн.<br>Жич: Соёлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6-д заасны дагуу Соёлын сайдын 2022 оны А/04 дүгээр тушаалаар Аймаг, нийслэлийн СУГ-ын зохион байгуулалтын бүтцийг баталсан ба 2023 онд бүтцэд өөрчлөлт ороогүй болно.<br><br>- "Салбарын хяналт шалгалтын 2023 оны төлөвлөгөө"-нд тусгагдсаны дагуу Соёлын салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулж, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. | |
| 4.2.3 | Арга хэмжээ-1.3 Соёл, урлагийн байгууллагуудад шилжин суурьшин ажиллах иргэдийг бодлогоор дэмжих. | Орон нутгийн төсөв | Орон нутагт шилжин суурьшихад орон сууц, бусад дэмжлэг Сургалт сурталчилгаа | - | Орон нутгийн соёлын байгууллагад хотоос шилжин суурьших иргэдэд дэмжлэг үзүүлсэн байна. | Аймгийн ИТХ-ын 2023 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан "Нээлттэй Дархан" хөтөлбөрийн 5.2-т заасны дагуу төрийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, орон нутагт шилжин суурьших, ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд:<br>**1. <u>Шарын гол сумын Соёлын төв:</u>** Бүжгийн багшийг Шарын гол сумын төрийн албан хаагчдын байранд түрээсийн төлбөргүй байрлуулан нийгмийн асуудлыг нь шийдвэрлэсэн.<br>**2. <u>Төв номын сан:</u>** УБ хотын Хүүхдийн төв номын сангаас номын санч мэдээллийн ажилтан мэргэжлийн дагуу шилжин ирсэн. Мөн Баянхонгор аймгийн сумын соёлын төвд ажиллаж байсан жолооч гэр бүлийн хамт тус аймагт шилжин ирснийг жолоочоор ажилд авсан.<br>**3. <u>Орхон сумын соёлын төв:</u>** Соёлын төвийн удирдлага, хөгжмийн багшаар 2 хүн ажилд томилогдож, мэргэжлийн боловсон хүчнийг 2-р нэмэгдүүллээ.<br>**4. <u>Хонгор сумын соёлын төв:</u>** Бүжгийн багшийг гэрээгээр ажиллуулж байна. | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5. **<u>Залуучууд театр:</u>** найруулагч Говь-Алтай аймгаас шилжин ирж ажиллаж байна.<br>**Хүрсэн түвшин:** Соёлын 5 байгууллагад 7 хүн шилжин ирж, орон байр, ажиллах орчин нөхцөлөөр хангагдан орон нутагт суурьшин ажиллаж байна. | |
| 4.2.4 | Арга хэмжээ-1.5 Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах талаар дэмжлэг үзүүлэх. | Улсын болон орон нутгийн төсөв | Хөнгөлөлттэй нөхцөлөөр сургах, ажилтны нийгмийн баталгаанд дэмжлэг үзүүлсэн байна. | - | Мэргэжлийн хүний нөөцийг өмнөх оноос 5-аас доошгүй хувиар нэмэгдүүлсэн байна.<br>Соёлын ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. | 1. Соёл, урлагийн газрын харьяа соёлын 7 байгууллагад нийт 158.5 ажиллагсад ажиллахаас жилийн эцсийн статистик мэдээгээр 154 албан хаагч ажиллаж байна. Үүний 124 буюу 80,5 хувь нь мэргэжлийн уран бүтээлч байна.<br><br>2. МУЗГ-ын 2023 оны 185 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын соёлын ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам"-ыг соёлын 7 байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллалаа. 2023 оны жилийн эцсийн байдлаар соёлын 7 байгууллагын 79 соёлын ажилтанд 366,684,226 төгрөгийн мөнгөн урамшуулал олгогджээ.<br><br>2. Соёлын сайдын 2023 оны А/390 дугээр тушаалаар баталсан “Соёлын байгууллагын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал”-д заасны дагуу харьяа соёлын 7 байгууллагын 138 албан хаагчид нэмэлтээр 25,2 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгож, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд 62 албан хаагчдад нийт 22.3 сая төгрөг зарцуулсан байна. Уг ажлын хүрээнд эрүүл мэндийн үзлэг оношилгоо, байгууллагын албан хаагчдад гэр болон галлагаатай байшинд түлээ, сайжруулсан шахмал түлш авах гэх мэт санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.<br><br>3. “Нээлттэй Дархан” хөтөлбөрийн 5.2-т заасны дагуу төрийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, орон нутагт шилжин суурьших, ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг тус газраас бүрдүүлэх хүрээнд **Соёлын 5** | 100 % |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | **байгууллагад 7 хүн шилжин ирж, орон байр, ажиллах орчин нөхцөлөөр хангагдан орон нутагт суурьшин ажиллаж байна**.<br><br>**<u>Ажиллах орчин нөхцлийг хангах хүрээнд:</u>**<br><u>- Соёл, урлагийн газар:</u> Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёлын сайд болон Дархан-Уул аймгийн Засаг дарга нарын 2023 онд хамтран ажиллах гэрээний 4.6-д заасны дагуу аймгийн удирдлагаас Дархан сумын 11 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах Багш хөгжлийн төвийн 1 дүгээр давхрын зүүн жигүүрт /171.6 м.кв талбай/ байрлан үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлж, ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлсэн.<br><br>**<u>Төв номын сан</u>** СУИС-ийн номын сангийн ангийн эчнээ ангид 4, номын санчийн чадамжийн төвийн сургалтад 2 албан хаагчийг хамруулаад байна. Номын санчдад зориулсан **5** удаагийн сургалтад давхардсан тоогоор **98** номын санчийг хамруулсан. “Анхны тусламжийн хайрцаг"-ийг ажлын байранд байршуулсан.<br>**<u>Музей</u>** **м**эргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор соёлын 2 ажилтан богино хугацааны сургалтад хамрагджээ.<br>**<u>Хүүхдийн номын ордон</u>** 15 ажилтан, албан хаагчдад шүдний эрүүл ахуйг хангах эмчилгээ хийлгэхэд 6.246.000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>**<u>Залуучууд театр</u>** мэргэжлийн урлагийн сургуультай хамтран 4 төрлийн мэргэшүүлэх сургалтад нийт 36 уран бүтээлчийг хамруулж сертификат олгосон. Дархан дээд сургуульд суралцаж буй 1 албан хаагчийн сэтгэл зүйчийн ангийг аялал жуулчлалын ангиар солиулж мэргэжлийн боловсон хүчин болгохоор бэлтгэж байна.<br>**<u>Шарын гол сумын соёлын төв</u>** “Цээнэ” эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээ байгуулж 8 албан хаагчийг эрүүл мэндийн үзлэг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинжилгээнд хамрууллаа. Хөгжмийн багшид эрүүл мэндийн байдлыг нь харгалзан үзэж байгууллагаас нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон. Нийт 15 сургалтад 36 уран бүтээлчийг хамруулж сертификат олгосон.<br><br>**Хүрсэн түвшин:**<br>- Соёл, урлагийн газрын харьяа соёлын 7 байгууллагад нийт 158.5 ажиллагсад ажиллахаас жилийн эцсийн статистик мэдээгээр 154 албан хаагч ажиллаж байна. Үүний 124 буюу 80,5 хувь нь мэргэжлийн уран бүтээлч байна.<br>- Төрийн анхан шатны үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, орон нутагт шилжин суурьших, ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг тус газраас бүрдүүлэх хүрээнд Соёлын 5 байгууллагад 7 хүн шилжин ирж, орон байр, ажиллах орчин нөхцөлөөр хангагдан орон нутагт суурьшсан.<br>- Соёлын байгууллагууд албан хаагчдын 2023 оны ажлын гүйцэтгэл, үр дүнг тодорхой шалгуураар үнэлж дүгнэн албан хаагчдад үндсэн цалингийн тодорхой хувиар тооцож, урамшуулал олгосны зэрэгцээ 2022 оны үйл ажиллагааг үнэлэн 138 албан хаагчдад үр дүнгийн урамшууллыг нэмэлтээр олгосон.<br>- 2023 оны жилийн эцсийн байдлаар соёлын 7 байгууллагын 79 соёлын ажилтанд 366,684,226 төгрөгийн 5 жилийн тэтгэмжийн мөнгөн урамшуулал олгосон.<br>- Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хүрээнд соёлын 7 байгууллагын 62 албан хаагчид нийт 22.3 сая төгрөг зарцуулсан.<br>- Соёлын салбарын албан хаагчдын орон сууцны нөхцөл, холбогдох судалгааг гарган аймаг, орон нутгийн удирдлагад танилцуулж, нийт албан хаагчдын орон сууцны нөхцөлийг сайжруулах, хямд чанар сайтай орон сууцаар хангах шат дараалсан арга хэмжээний хүрээнд орон сууцны газар бариулах зориулалтаар 2024 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны газар зохион байгуулалтын төлөвлөлтөд саналаа өгсөн.<br>- 66 удаагийн сургалт, мэдээллийн арга хэмжээнд давхардсан тоогоор 381 ажилтныг хамрууллаа.<br>-Тус аймагт үйл ажиллагаа явуулж буй Соёл, урлагийн газар, харьяа Соёлын 7 байгууллагын нийт 169 ажилтнаас 121 буюу 72 хувь нь эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношилгоонд өрхийн эмнэлгээс ирүүлсэн цагийн хуваарийн дагуу хамрагдлаа. | |
| 4.2.5 | Арга хэмжээ-1.8 Хүний эрх, хүүхэд хамгаалал, гэр бүл, залуучуудын хөгжилд соёлын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах. | Орон нутгийн төсөв | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 3-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | -Хүний эрх: “Аядуун” тоглолт 450 үзэгч, "Хүний эрх, эрх чөлөө" шог зургийн үзэсгэлэн 487, Хувь хүний хөгжлийн сургалтад 8 албан хаагч, Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн нээлтээр 35 үйл ажиллагаанд 500 гаруй хүүхэд оролцож 1000 гаруй үзэгч, хүний эрхийг хамгаалах “Үзэсгэлэнт” сургалтад 51, Жендерт суурилсан эрүүл харилцааны тухай 8 контент<br>-Хүүхэд, гэр бүл, залуучуудад: Соёлын байгууллагуудын “Эцэг эхийн зөвлөл” нийт 48 нөлөөллийн ажил, “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах” сургалтад 10 албан хаагч, “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сургалтад 11 албан хаагч, Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх "Айдсын ном" киног 4400 гаруй хүүхэд үзлээ.<br>-“Хөшиг нээгдэх бүрт-хүргэх нэг үг”, “Хүүхэд хөгжлийн хувийг бий болгох” уриан дор соёлын байгууллагууд нийт 89 арга хэмжээнд 35,218 /давхардсан тоогоор/ хүнийг хамруулж цахим орчинд 28 арга хэмжээг 45,699 хүнд, Хүүхдийн хөгжил, хамгааллалд олсон орлогоноосоо 9,127,100 төгрөгийг зарцуулжээ.<br>-“БИД ЭХ ОРНЫ ИРЭЭДҮЙ” эх оронч үзлийг төлөвшүүлэх өдөрлөгт 712 сурагч, Дауны синдромоор дамжуулан олон нийтэд боловсрол олгох зорилготой “Трио” УСК-ны нээлтийг | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулсан.<br>-“Нэгдүгээрт хүүхэд” аяны хүрээнд сумдын Соёлын төвд 11 дугуйланд 182 хүүхэд, Залуучууд театр 42 удаагийн тоглолтыг 11 төрлийн дугуйланд 108 хүүхэд хамруулав.<br>-Соёлын байгууллагууд 19 боловсролын хөтөлбөрийг 256 удаа зохион байгуулж 8614 хүнийг хамруулсан.<br>-Цахим сурталчилгаа, шторк, постер нийт 26,354 хүн,<br>-Соёлын салбарын Залуучууд хөгжлийн зөвлөлөөс 7 арга хэмжээ зохион байгуулав.<br>**:Хүрсэн түвшин**Хүний эрх, хүүхэд хамгаалал, гэр бүл, залуучуудын хөгжилд зориулсан 43 арга хэмжээнд 69000 гаруй хүн хамрагджээ. Хүүхдийн хөгжлийг дэмжсэн урлагийн тоглолтыг 42 удаа зохион байгуулж 17300 хүүхэдүзсэн .байна | |
| 4.2.6 | Арга хэмжээ-1.9 Хүчирхийлэл, дайн түрэмгийлэл, гэмт хэрэг, садар самууныг сурталчилсан соёлын үйл ажиллагааг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. | Орон нутгийн төсөв | Урьдчилан сэргийлэхээр зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | 5-аас доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна. | .1Охидын хүчирхийллийн эсрэг “ICE TOP” хамтлагийн шинээр гаргасан “Хэцүү биш хүсэл” дууны уран бүтээлийг цахимд байршуулж 1560 хүнд хүргэсэн.<br>2.“Хөшиг нээгдэх бүрт-хүргэх нэг үг” аяны хүрээнд соёл, урлагийн байгууллагууд нийт 18 нөлөөллийн ажил хийж, 278 ширхэг хүчирхийллийн эсрэг материал хэвлэн тарааж, цахим орчинд 6 зурагт хуудас бэлтгэн байршуулан санал зөвлөмж хүргэж, 2852 хүнд хүрсэн.<br>.3 Музей 2 сэдвээр түр үзэсгэлэн гаргаж, 800 хүнд үйлчилгээ үзүүлсэн.<br>4. Бодит амьдралаас сэдэвлэсэн, харамсалтай байдлаар амиа алдсан, хүсэл мөрөөдлөөр дүүрэн хүүгийн дурсгалд зориулж хийгдсэн “Зүрхэнд гэрэлтэнэ” УСК Дархан хотноо нээлтээ хийсэн. Өсвөр насны хүүхдүүдийг хүсэл мөрөөдлийнхөө төлөө зүтгэх, амьдралын зорилготой байх, зам тээврийн осол, гэмтлээс сэргийлье уриатай энэхүү уран бүтээлийг туурвиж, киноны орлогын тодорхой хувийг сайн | 100 % |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлсэд зарцуулах зорилгоор “Хүүхдийг зам тээврийн ослоос хамгаалах сан”-г байгуулсан.<br>5."Нийгэмд шударга ёсыг бэхжүүлье! Хүүхдийн хөдөлмөрийг устгая! аянд соёлын байгууллагууд нэгдэж нийт 18 нөлөөллийн ажлыг зохион байгуулж 256 хүнийг хамрагдсан.<br>**Хүрсэн түвшин:** Нийт 5 арга хэмжээ зохион байгуулж 5468 хүнийг хамруулж, 5 уран бүтээлийг 31 удаа гаргаж 10852 үзэгчдэд толилуулжээ. | |
| **Дөрөв. Тайлант хугацаанд гүйцэтгэсэн нэмэлт ажлын хүрээнд:** | | | | | | | |
| **Зорилт-4.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд:** | | | | | | | |
| 4.1.1 | Арга хэмжээ-1<br>Авто ралли уралдаан зохион байгуулах. | - | Арга хэмжээний тоо | - | Арга хэмжээ зохион байгуулсан байна. | "Чингис мастер кросс 2023" уралдааныг зохион байгуулж, нээлтийн үйл ажиллагаанд тайз, техник тоног төхөөрөмжөөр дэмжлэг үзүүлж, ая дууны мэндчилгээ хүргэсэн. Монголын мастер кросс ангилалд нийт 63 тамирчин оролцож, хэсгийн 4, хагас шигшээ 2, финалын 1 гараанаас шилдгүүд тодорч шагнал гардуулах үйл явц, сурталчилгааны 2 зурагт хуудсыг сошиалаар түгээж, фото болон видео мэдээ бэлтгэн олон нийтэд сурталчилсан. | 100% |
| 4.1.2 | Арга хэмжээ-2<br>Тогтвортой аялал жуулчлал өдөрлөгийн нээлтийг зохион байгуулах. | - | Арга хэмжээний тоо | - | Арга хэмжээ зохион байгуулсан байна. | Дархан-Уул аймгийн ЗДТГ, Найрамдал төслөөс зохион байгуулсан "Тогтвортой аялал жуулчлал" чадавхжуулах сургалтын нээлттэй өдөрлөгт Залуучууд театрын уран бүтээлчид урлагийн тоглолт үзүүлж "Угсаатан бий" төслийн сургалтад хамрагдсан сурагчид бий биелэгээ хийж, олон нийтэд толилуулсан. | 100% |
| 4.1.3 | Арга хэмжээ-3<br>Эрүүл мэндийн өдөрлөгт оролцох. | - | Арга хэмжээний тоо | - | Арга хэмжээ зохион байгуулсан байна. | 1. “Эрүүл Монгол хүн” үндэсний фестивалийг олон нийтэд нээлттэй хэлбэрээр зохион байгуулахад Нийтийн бүжгийн холбооны ДУА дахь салбар зөвлөл, Ирээдүй бүжгийн клубтэй хамтран “ШУГАМАН БҮЖИГ”-ээр оролцож, эрүүл хооллон дасгал хөдөлгөөн хийж, эрүүл байхыг уриаллаа.<br>2. “Энэ жилдээ- Эрүүл жиндээ”, “Эрүүл амьдрал- идэвхтэй хөдөлгөөн”, “Цаг гаргая” аяны хүрээнд байгууллагын албан хаагчид иогийн сургалтад хамрагдаж, ажлын байрны дасгалыг бичлэгээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийж 20 удаа сунних давалгааг цахимаар эхлүүлсэн. | |
| 4.1.4 | Арга хэмжээ-4. “MIND UPDATE” төслийг дэмжиж ажиллах. | - | Арга хэмжээний тоо | - | Арга хэмжээ зохион байгуулсан байна. | JCI Их Хүрээ салбараас санаачлан хэрэгжүүлсэн “Mind update” төслийг Соёлын яам дэмжиж, хувь хүний хөгжлийн сургалтыг аймгийн СУГ, БШУГ хамтран зохион байгуулж, ЕБС-ийн ахлах ангийн 500 гаруй сурагчийг хамруулсан. | 100% |
| 4.1.5 | Арга хэмжээ-5. “Галерей аялж байна” хөтөлбөрийг Дархан хотноо зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх. | - | Арга хэмжээний тоо | - | Арга хэмжээ зохион байгуулсан байна. | Монголын Уран зургийн галерей нь олон нийтийн урлагийн боловсролын цар хүрээ, соёл, урлагийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор “Галерей аялж байна” хөтөлбөрийг Дархан-Уул аймагт зохион байгуулсан. Уг хөтөлбөрийн хүрээнд "Монголын шилдэг уран зургууд" нүүдлийн тусгай үзэсгэлэн, "Хөгжимтэй зураг" хөтөлбөр, "Хандлагааар анагаахуй" урлагийн сэтгэл заслын хөтөлбөр, "Цаг хугацаагаар аялагч" олон нийтийн оролцоот урлагийн бүтээлийг үзэгчдэд толилуулав. | 100% |
| 4.1.6 | Дархан хотын ойг тохиолдуулан “Дархан дрифт-2023” тэмцээнийг хамтран зохион байгуулах. | Орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөг | Арга хэмжээний тоо | - | Арга хэмжээ зохион байгуулсан байна. | Аймгийн Засаг даргын санаачилгаар “Дархан дрифт 2023-Mongolian drift series Final round” улсын тэмцээнийг аймгийн ЗДТГ, Монголын мэргэжлийн спорт авто машины холбоотой хамтран зохион байгууллаа. Тус тэмцээнд мэргэжлийн ангилалд 31, сонирхогчдын ангилалд 36 нийт 67 тамирчин оролцсон. | 100% |
| 4.1.7 | Дархан хотын ойг тохиолдуулан “Car cinema” машинтай киног гаргахад хамтран ажиллах. | Орон нутгийн төсвөөс 3.5 сая төгрөг | Арга хэмжээний тоо | - | Арга хэмжээ зохион байгуулсан байна. | Найрамдал талбайд “Car cinema“ машинтай кино үзвэрийг Аймгийн ЗДТГ, Найрамдал төслийн дэмжлэгтэйгээр Galaxy car cinema, аймгийн ЦГ-ын ЗЦТ, Дархан хотын соёл амралтын хүрээлэн, Эхлэл Радио 87.9 зэрэг байгууллагуудтай хамтран 2 удаа зохион байгуулсан. Нийт 100 гаруй машинтай үзэгч үзлээ. | 100% |
| **Тав. Тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн /биелэлтийн хувь/** | | | | | | | 98,8 **7%** |

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ТАЙЛАНГ ХЯНАСАН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ЦАСЧИХЭР

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:
НИЙГМИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН Л.БУЯНХИШИГ

СОЁЛЫН САЙДААС ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ 2023 ОНД ЗАСГИЙН ГАЗРЫН ЗАРИМ ЧИГ ҮҮРГИЙГ ОРОН НУТАГТ ТӨЛӨӨЛӨН ХЭРЭГЖҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ҮҮРГИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2023.12.18

| № | Зорилт / Үнэлгээ | | Бүгд | Нэг. Хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд | Хоёр. Байгууллагын чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх зорилтын хүрээнд | Гурав. Байгууллагын үйл ажиллагааны нээлттэй байдлын хүрээнд | Дөрөв. Тайлант хугацаанд гүйцэтгэсэн нэмэлт ажлын хүрээнд |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хяналтанд авсан арга хэмжээний тоо | | 56 | 21 | 22 | 6 | 7 |
| 2. | Үнэлгээ, үүнээс | 100.0% | 47 | 20 | 18 | 2 | 7 |
| | | 90.0% | 5 | 1 | 3 | 1 | - |
| | | 70.0% | 3 | - | 1 | 2 | - |
| | | 50% | 1 | - | - | 1 | - |
| | | 30% | - | - | - | - | - |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | 0% | - | - | - | - | - |
| **Ерөнхий үнэлгээ** | | | **96.60% буюу 4.83 оноо** | **99.52% буюу 4.97 оноо** | **97.27% буюу 4.86 оноо** | **80.0% буюу 4.0 оноо** | **100% буюу 5.0 оноо** |

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН